



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 05 өдөр

Дугаар А/24

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сүж овогт Дугаржавын Нарантуяа /ХИ65041000/ нь Шивээговь сумын 1 дүгээр баг, 2, 3 дугаар байрны хойд талд байрлах “Автомашинны гараж”-ийн зориулалттай 21 м2 газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Бууч овогт Дорлигийн Зүгээрсайхан /ЕЙ69060403/-д Шивээговь сумын 1 дүгээр баг, 2, 3 дугаар байрны хойд талд байрлах, 21 м2 газрыг “Автомашинны гараж”-ийн зориулалтаар өмнө нь авсан иргэний үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Монгол улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн (Д.Зүгээрсайхан)-д үүрэг болгосугай.

3.Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Д.Зүгээрсайхантай газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Өлзийбуд)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/185 дугаар захирамжийн хавсралтын 1 дэх бүртгэлийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА